

- 5.23. Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь Холбооны бүх гишүүдийн хурал хуралдахаас нэг сарын өмнө хувийн танилцуулга, 4 жилийн хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр зэргийг удирдах зөвлөлд ирүүлсэн байна.
- 5.24. Ерөнхийлөгчийг Холбооны бүх гишүүдийнхуралд оролцсон нийт гишүүдийн олонхийн саналаар, дөрвөн жилийн хугацаатай сонгоно.
- 5.25. Ерөнхийлөгч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ;
  - 5.25.1. Бүх гишүүдийн хурал, Удирдах зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үйл ажиллагааг удирдлаганаар хангах;
  - 5.25.2. Холбоонызорилгыг биелүүлэхэд чиглэсэн бодлого, төлөвлөгөө боловсруулж Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж, мөрдөж ажиллах;
  - 5.25.3. Удирдах зөвлөлийн хурлыг зарлан хуралдуулж,хурлыг даргалах;
  - 5.25.4. Холбоог гадаад, дотоод харилцаанд итгэмжлэлгүйгээр төлөөлөх, гадаад хамтын ажиллагааг хариуцах;
  - 5.25.5. Ажлын албаны ажлын хуваарь, орон тооны дээд хязгаар, цалин, хөдөлмөрийн хөлсний хэмжээг тогтоож, ажилд авах болон ажлаас халах журмыг батлах;
  - 5.25.6. Холбооны бүтцийг тодорхойлж, Удирдах зөвлөлөөр батлуулах;
  - 5.25.7. Холбооны ээлжит бус их хурлыг зарлан хуралдуулах;
  - 5.25.8. Удирдах зөвлөл болон бусад дотоод дүрэм журмаар эрх олгогдсон бусад бүрэнэрх.
- 5.26. Ерөнхийлөгч нь Холбооны бүх гишүүдийн хуралд ажлаа тайлagnana.
- 5.27. Ерөнхийлөгчийг бүрэн эрхийн хугацаа дууссан, дүрмийн бус үйл ажиллагаа явуулсан, гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон, эрүүл мэндийн хувьд хэвийн ажиллах боломжгүй болсон нь эмнэлгийн магадлагаагаар тогтоогдсон, өөрийн хүсэлтээр татгалзсан үндэслэлээр үүрэгт ажлаас нь чөлөөлнө.
- 5.28. Холбооны Ерөнхийлөгч жилд **10,000,000 /арван сая/-аас** доошгүй төгрөгийг холбооны үйл ажиллагааны зардалд зориулан дэмжлэг хэлбэрээр оруулна.

#### Дэд ерөнхийлөгч

- 5.29. Холбоо нь мэргэжлийн тодорхой асуудлыг дагнан хариуцсан Дэд ерөнхийлөгчтэй байна.
- 5.30. Холбооны Дэд ерөнхийлөгчийг Ерөнхийлөгчийн санал болгосноор Удирдах зөвлөлийн гишүүдээс сонгоно.
- 5.31. Дэд ерөнхийлөгчдийн тоо Ерөнхийлөгчийн саналаар Удирдах зөвлөл төгрөнө
- 5.32. Дэд ерөнхийлөгч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 5.32.1. Хариуцсан чиглэлээрээ мэдээ мэдээлэлцүглуулансудалж,дүгнэлтгаргаж Ерөнхийлөгч,Удирдахзөвлөлтанилцуулж,Удирдахзөвлөлболонгишүүнбайгуулл агуудыгмэдээлэл, зөвлөмжөөр хангажиллах;
  - 5.32.2. Хариуцсан чиглэлээрэхолбооболонтүүнийхамтран ажилладаг олон улсын байгууллагуудын угасуудлыгэрхэлсэн албан тушаалтнуудтай үр бүтээлтэй хамтран ажиллах;
  - 5.32.3. Хариуцсан чиглэлийн хүрээнд дараах чиг үүргийг баримтлан ажиллана. Үүнд:
    - а. Холбооны зорилго чиглэлийгсурталчлан таниулах;